

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2025/007/НА-СТА-ТТЗ

Чингис хот 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn Аудитын менежер: Д.Оюунтуяа Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn Аудитор: Н.Туяа Утас: 99799709 Цахим хаяг: tuyan@audit.gov.mn Цахим хаяг: www.audit.mn
-----------------------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас:70-56-21-12, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2025.03.24 № 403

танай _____ -ны № _____ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН ЦЭНХЭРМАНДАЛ
СУМЫН ЗАСАГ ДАРГА
А.МӨНХ-ОРГИЛ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар Засаг даргын харьяаны сумын Иргэдийн төлөөлөгчдийн хуралд холбогдох 1,283.7 мянган төгрөгийн, Засаг даргын Тамгын газарт холбогдох 10,162.3 мянган төгрөгийн, Цэнхэрмандал хөгжил ОНӨҮГ-т холбогдох 80,591.1 мянган төгрөгийн нийт 4 зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

Төрийн албан тушаалд тогтвор суурьшилтай тасралтгүй 5 жил ажиллаагүй ажилтанд нэг удаагийн мөнгөн урамшуулал 7,326.7 мянган төгрөгийг олгосон, төрийн захиргааны ажилтнуудад олгосон урамшууллаас 4,323.8 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутгаагүй, 80,591.1 мянган төгрөгийн бараа материалыг нийлүүлэгч байгууллагын борлуулалтын баримтыг үндэслэж орлогод аваагүй, шаардах хуудасны дагуу зарцуулалт хийж тайлан гаргаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны 83 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.1-д "Сум болон нийслэлийн Багахангай, Багануур, Налайх

232520403

дүүрэгт Төрийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан албан тушаалд томилогдон тасралтгүй 5 жил (60 сар), түүнээс дээш хугацаагаар ажилласан төрийн захиргааны албан хаагч мөнгөн урамшуулал авна”, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1 "Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.4-т "Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэснийг тус тус зөрчсөн байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд сумын татварын ба татварын бус орлогоос 1,129,493.7 мянга, сумын төсөвт аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс 826,467.8 мянга, орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгээс 859,241.5 мянга, үндсэн болон туслах үйл ажиллагаанаас 17,679.0 мянган төгрөгийг бүрдүүлж, 2,546,376.0 мянган төгрөгийг зарцуулж, 89,496.4 мянган төгрөгийг сумын төсвийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлжээ.

Аудитын гол асуудал

Харьяа орон нутгийн төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 376,683.5 мянган төгрөгийн 11 алдаа, зөрчил илрүүлснээс 284,441.9 мянган төгрөгийн 9 алдааг санхүүгийн тайланд аудитын явцад залруулж, 92,241.6 мянган төгрөгийн зөрчилд 11,650.5 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 80,591.1 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлжээ. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд алдаа, зөрчил илрээгүй.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 27-ны хуралдааны 12 дугаар тогтоолоор сумын Засаг даргын 2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнг "Хангалттай" гэж дүгнэсэн байна.

Орон нутгийн төсөвт 1,042,400.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 87,093.7 мянган төгрөгөөр давуулан биелүүлж, биелэлт 108.4 хувьтай байна. Үүнд 11 нэр төрлийн орлогын төлөвлөгөө 280.7 хувиас 100 хувиар биелж, Үл хөдлөх хөрөнгийн албан татвар 38.1 хувиар, малын тоо толгойн албан татвар 6.8 хувиар, улсын тэмдэгтийн хураамжийн орлого 3.1 хувиар тус тус тасарсан байна.

Орон нутгийн хөгжлийн сангаар 1,019,660.3 мянган төгрөгийн 33 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 25 ажлыг 621,401.9 мянган төгрөгөөр гүйцэтгүүлснээс 4 ажил бүрэн дуусаагүй, 372,067.5 мянган төгрөгийн 4 арга хэмжээг хэрэгжүүлээгүй байна.

Цаашид төсвийн төсвийн орлого, зарлагыг үндэслэлтэй төлөвлөж, орлогыг нэр төрлөөр нь биелүүлэх, батлагдсан төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж. ГАНБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		626,098.60	1,263,522.50
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	364,443.60	638,311.40
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	129,086.20	446,152.90
34	УРЬДЧИЛГАА	7а, 7б	14,000.00	21,500.00
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	118,568.70	157,558.20
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		3,002,111.70	6,757,927.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	3,002,111.70	6,757,927.00
39200	Биет хөрөнгө		2,562,533.70	6,318,349.00
39300	Биет бус хөрөнгө	13	439,578.00	439,578.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		3,628,210.20	8,021,449.50
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		42,430.10	39,290.50
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	42,430.10	39,290.50
41300	Өглөг	17а, 17б	40	291.5
41400	Урьдчилж орсон орлого	18а, 18б	42,390.10	38,998.90
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		3,585,780.10	7,982,159.00
51	Засгийн газрын хувь оролцоо		3,585,780.10	7,982,159.00
51100	Засгийн газрын оруулсан капитал		1,603,076.40	1,603,076.40
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/		34,230.50	34,230.50
51200	Хуримтлагдсан үр дүн		1,904,903.00	6,301,281.90
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		43,570.20	43,570.20
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		3,628,210.20	8,021,449.50

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		3,394,160.80	9,132,590.10
11	ТАТВАРЫН ОРЛОГО		474,468.10	861,153.20
110	Орлогын албан татвар		187,990.70	375,810.80
1100	Хувь хүний орлогын албан татвар		187,990.70	375,810.80
113	Хөрөнгийн албан татвар		104,282.60	105,517.20
118	Бусад татвар, төлбөр, хураамж		182,194.80	379,825.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	700,361.80	4,531,165.90
120	Нийтлэг татварын бус орлого		700,361.80	4,531,165.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,219,330.90	3,740,271.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	2,993,383.80	4,279,559.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,993,383.80	4,279,559.80

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,633,167.10	2,157,772.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		465,442.50	813,157.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		57,407.50	105,574.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		28,432.20	333,213.00
2104	Хангамж, бараа материалын зардал		54,720.50	60,794.30
2105	Нормативт зардал		4,828.90	1,657.10
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		62,664.60	77,320.60
2107	Томилолт, зочны зардал		21,350.00	22,983.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		521,819.20	261,021.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		416,501.80	482,051.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,360,216.70	2,121,787.10
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		400,777.00	4,853,030.30
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		328,082.80	456,205.50
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		72,694.20	4,396,824.80

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		3,111,249.20	5,095,652.10
11	ТАТВАРЫН ОРЛОГО		474,468.10	861,153.20
110	Орлогын албан татвар		187,990.70	375,810.80
1100	Хувь хүний орлогын албан татвар		187,990.70	375,810.80
113	Хөрөнгийн албан татвар		104,282.60	105,517.20
118	Бусад татвар, төлбөр, хураамж		182,194.80	379,825.20
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж		32,596.70	35,186.10
1181	Газрын төлбөр		121,976.40	300,983.30
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр		27,621.70	43,655.80
1183	Бусад татвар		0	0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		417,450.10	494,227.90
120	Нийтлэг татварын бус орлого		417,450.10	494,227.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,219,330.90	3,740,271.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		2,595,995.20	3,947,118.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,595,995.20	3,947,118.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,237,602.00	1,825,331.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		486,769.90	836,999.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		61,249.20	109,207.10

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		27,054.70	337,208.40
2104	Хангамж, бараа материалын зардал		84,118.30	180,101.90
2105	Нормативт зардал		2,084.40	1,807.10
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		30,928.00	70,941.50
2107	Томилолт, зочны зардал		20,878.00	22,981.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		454,953.90	131,380.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		69,565.50	134,704.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,358,393.20	2,121,787.10
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		515,254.00	1,148,533.80
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)		0	0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		422,243.80	734,966.10
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		422,243.80	734,966.10
2200	Дотоод эх үүсвэрээр		422,243.80	734,966.10
2260	Гадаад эх үүсвэрээр		0	0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		-422,243.80	-734,966.10
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		-18,000.00	-139,700.00
14	Бусад эх үүсвэр		0	0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ		18,000.00	139,700.00
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		0	0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		75,010.20	273,867.70
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		289,433.40	364,443.60
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		364,443.60	638,311.40

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,513,085.90	0	3,513,085.90
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	7,611.50	0	7,611.50
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,520,697.40	0	3,520,697.40
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-7,611.50	0	-7,611.50

5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0
7	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0
8	Зарласан ногдол ашиг	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	72,694.20	0	72,694.20
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,585,780.10	0	3,585,780.10
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,585,780.10	0	3,585,780.10
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,585,780.10	0	3,585,780.10
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-445.9	0	-445.9
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0
17	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	4,396,824.80	0	4,396,824.80
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	7,982,159.00	0	7,982,159.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,103,750.3	2,546,376.0	557,374.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,839,438.9	1,742,274.1	97,164.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,765,458.4	1,668,414.5	97,043.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	830,453.1	778,638.1	51,815.0
210101	Үндсэн цалин	356,935.7	360,321.2	-3,385.5
210102	Нэмэгдэл	305,144.0	296,898.7	8,245.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	32,890.0	32,092.9	797.1
210104	Урамшуулал	52,017.0	27,274.7	24,742.3
210105	Гэрээт ажлын хөлс	83,466.4	62,050.5	21,415.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	103,806.5	98,247.5	5,559.0
210201	Тэтгэврийн даатгал	70,588.2	66,255.4	4,332.8
210202	Тэтгэмжийн даатгал	8,304.5	8,158.6	145.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,152.4	4,079.4	73.0
210204	Ажилгүйдлийн даатгал	4,152.4	4,038.3	114.1
210205	Эрүүл мэндийн даатгал	16,609.0	15,715.9	893.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	350,395.7	336,379.6	14,016.1
210301	Гэрэл, цахилгаан	40,483.9	32,241.7	8,242.2
210302	Түлш, халаалт	301,384.2	296,087.9	5,296.3
210303	Цэвэр, бохир ус	8,527.6	8,050.0	477.6
2104	Хангамж, бараа материалын зардал	54,545.4	54,454.9	90.6
210401	Бичиг хэрэг	5,290.3	5,243.7	46.6
210402	Тээвэр, шатахуун	40,000.0	39,998.6	1.4

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,692.2	4,726.9	-34.7
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,076.5	1,000.0	76.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,486.4	3,485.7	0.7
2105	Нормативт зардал	1,807.1	1,807.1	0.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,807.1	1,807.1	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	106,247.1	105,046.9	1,200.2
210601	Багаж, техник, хэрэгсэл	27,542.9	27,505.4	37.5
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,943.1	1,943.1	0.0
210604	Урсгал засвар	76,761.1	75,598.4	1,162.7
2107	Томилолт, зочны зардал	23,475.0	22,391.0	1,084.0
210702	Дотоод албан томилолт	23,475.0	22,391.0	1,084.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	153,448.5	143,046.2	10,402.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	143,120.0	135,801.2	7,318.8
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	999.3	588.0	411.3
210803	Даатгалын үйлчилгээ	620.0	620.0	0.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	614.0	560.8	53.2
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	245.0	245.0	0.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,886.7	3,268.1	2,618.7
210807	Газрын төлбөр	1,963.5	1,963.2	0.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	141,280.0	128,403.3	12,876.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	136,645.0	123,772.4	12,872.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,635.0	4,630.8	4.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	73,980.5	73,859.6	120.9
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	11,300.0	11,288.7	11.4
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	11,300.0	11,288.7	11.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	62,680.5	62,570.9	109.6
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	50,654.0	50,575.2	78.8
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,026.5	11,995.7	30.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,062,660.3	664,401.9	398,258.4
223001	Бусад хөрөнгө	1,062,660.3	664,401.9	398,258.4
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	201,651.1	139,700.0	61,951.1
230001	Эргэж төлөгдөх зээл	201,651.1	139,700.0	61,951.1
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,103,750.3	2,834,951.6	268,798.7
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,826,380.4	2,817,272.6	9,107.8
320001	Орон нутгийн төсвөөс	1,967,138.9	1,958,031.1	9,107.8
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	859,241.5	859,241.5	0.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	277,369.9	17,679.0	259,690.9
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,000.0	11,179.0	8,821.0
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,300.0	6,500.0	-1,200.0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	252,069.9	0.0	252,069.9

4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	252,069.9	-252,069.9
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	451,149.1	-451,149.1
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2	0
610001	Төсвийн байгууллага	2	2	0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	27	27	0
620001	Удирдах ажилтан	8	8	0
620002	Гүйцэтгэх ажилтан	9	9	0
620003	Үйлчлэх ажилтан	5	5	0
620004	Гэрээт ажилтан	5	5	0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	27	27	0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10	10	0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	10	10	0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7	7	0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,034.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,034.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,634.2
2104	Хангамж, бараа материалын зардал	3,167.2
210401	Бичиг хэрэг	0.0
210402	Тээвэр, шатахуун	3,167.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,467.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,467.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	400.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	400.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	7,034.2
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,034.2
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	3,000.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,630.3
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	403.9

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Цэнхэрмандал сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 1 төрийн сангийн, 3 тусгай сан, Ойн анги, Цэнхэрмандал хөгжил

ОНӨҮГ-ын нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс аймаг дахь Төрийн аудитын газар ЗДТГ-ын санхүүгийн тайланд аудит хийж “Өөрчлөлтгүй” дүгнэлт, Платиниум прогресс аудит ХХК Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд гэрээгээр гүйцэтгэж “Өөрчлөлтгүй” дүгнэлт, Стандарт дүгнэлт аудит ХХК Хүүхдийн цэцэрлэг, ЕБС-ийн санхүүгийн тайлангийн аудитыг гэрээгээр гүйцэтгэж “Өөрчлөлтгүй” дүгнэлт тус тус өгсөн.

ИТХ, Хоршоо хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сан, Соёлын төв, Ой анги ОНӨҮГ, Цэнхэрмандал хөгжил ОНӨҮГ аудитын түүвэрт хамрагдсан болно.

3.1. Тус сумын харьяа орон нутгийн төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 376,683.5 мянган төгрөгийн 13 алдаа, зөрчил илрүүлснээс 284,441.9 мянган төгрөгийн 9 алдаа¹г санхүүгийн тайланд аудитын явцад залруулж, 11,650.5 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 80,591.1 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн.Үүнд:

ЗДТГ: 1. Санхүүгийн тайланд 90,604.0 мянган төгрөгийн 3 алдааг залруулсан. Үүнд:

- Засаг даргын нөөц хөрөнгөөс Соёлын төвд олгохоор худалдаж авсан 4,000.0 мянган төгрөгийн морин хуурыг үндсэн хөрөнгөд бүртгэсэн
- Зураг төсөв гаргуулах гэрээний дагуу шилжүүлсэн 7,500.0 мянган төгрөгийн урьдчилгааг санхүүгийн тайланд урьдчилж төлсөн зардлаар бүртгээгүй зардалд хаасан
- Санхүүгийн тайланд тайлант оны 79,104.0 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг дутуу илэрхийлсэн алдааг тус тус залруулав.

2. Төрийн албан тушаалд тогтвор суурьшилтай тасралтгүй 5 жил ажиллаагүй ажилтанд нэг удаагийн мөнгөн урамшуулал 7,326.7 мянган төгрөгийг олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоов.

3. Төрийн албанд тогтвор суурьшилтай ажилласны нэг удаагийн мөнгөн урамшууллаас 2,835.6 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг суутгаж төсөвт төвлөрүүлээгүй зөрчилд төлбөрийн акт тогтоов.

ИТХ: 1. Санхүүгийн тайланд 1,283.7 мянган төгрөгийн 2 алдааг залруулсан. Үүнд:

- Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдлийг дэлгэрэнгүй тайлангаас 445.9 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн.
- Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийн элэгдлийг дэлгэрэнгүй тайлангаас 837.8 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн.

2. Төрийн албанд тогтвор суурьшилтай ажилласны нэг удаагийн мөнгөн урамшууллаас 1,488.2 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг суутгаж төсөвт төвлөрүүлээгүй зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

Цэнхэрмандал хөгжил ОНӨҮГ:

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Бараа материалыг нийлүүлэгч байгууллагын борлуулалтын баримтыг үндэслэж орлогод аваагүй, баримтад хавсаргаагүй, шаардах хуудасны дагуу зарцуулалт хийж тайлан хөтлөөгүй 80,591.1 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

ОНХС: Тайлант онд гүйцэтгэл нь дуусаагүй 4 ажилд олгосон 165,196.5 мянган төгрөгийн урьдчилгааг урьдчилж төлсөн зардлаар бүртгээгүй, зардалд хаасан алдааг залруулсан.

Хоршоо хөгжүүлэх сан: 1. Санхүүгийн тайланд 27,357.7 мянган төгрөгийн 3 алдааг залруулсан. Үүнд

- Авлагын эхний үлдэгдлийг дэлгэрэнгүй тайлангаас 1,120.8 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн.
- Зээлийн эргэн төлөлтийг дэлгэрэнгүй тайланд 1,480.0 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн.
- Орлого үр дүнгийн тайланд хүүгийн орлогыг 24,756.9 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн алдааг залруулав.

3.2. Тус сумын харьяа улсын төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 19,240.7 мянган төгрөгийн 4 алдаа, зөрчил илрүүлснээс 14,610.0 мянган төгрөгийн 2 алдааг санхүүгийн тайланд залруулж, 4,630.7 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

Соёлын төв: Санхүүгийн тайланд 14,610.0 мянган төгрөгийн 2 алдааг залруулсан. Үүнд:

- Ном болон мэдээний программын 2025 оны төлбөрт 510.0 мянган төгрөгийг урьдчилж төлж, зардалд хаасан.
- Бараа материалд 9,600.0 мянган төгрөгийн уурын зуух, 4,500.0 мянган төгрөгийн хашааг бүртгэснийг залруулав.

Ерөнхий боловсролын сургууль: Нягтлан бодогчийн ажлыг улирал бүр дүгнэж, үр дүнгийн мөнгөн урамшууллыг тухай бүр олгосон боловч эрхлэгчийн тушаалаар санхүүгийн тайлангийн аудитаар “Өөрчлөлтгүй” дүгнүүлсэн гэх үндэслэлээр нягтлан бодогчоор ажиллаж байсан ажилтанд 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний урамшуулал 1,471.0 төгрөгийг давхардуулан олгосон зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

Эрүүл мэндийн төв: Тайлант онд эрхлэгчид 1,203.5 мянган төгрөг, нягтлан бодогчид 1,471.0 мянган төгрөг, вакциначид 485.2 мянган төгрөг, нийт 3,159.7 мянган төгрөгийн урамшууллыг үр дүнгийн урамшуулалтай давхардуулан, төсвийн жил дамнуулан олгосон зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

3.3 Сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар зөрчил илрээгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье. илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулагдаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	3	90,604.0			3	90,604.0	3	90,604.0				
ИТХ	2	1,283.7			2	1,283.7	2	1,283.7				
ОНХС	1	165,196.5			1	165,196.5	1	165,196.5				
ХХС	3	27,357.7	1	24,756.9	2	2,600.8	3	27,357.7				
ОНТБ-ын дүн	9	284,441.9	1	24,756.9	8	259,685.0	9	284,441.9				
Соёлын төв	2	14,610.0			2	14,610.0	2	14,610.0				
УТБ-ын дүн	2	14,610.0	0	0	2	14,610.0	2	14,610.0				
Дүн	11	299,051.9	1	24,756.9	10	274,295.0	11	299,051.9	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	2	10,162.3	2	10,162.3								
ИТХ	1	1,488.2	1	1,488.2								
Цэнхэрмандал хөгжил	1	80,591.1			1	80,591.1						
ОНТБ-ын дүн	4	92,241.6	3	11,650.5	1	80,591.1	0	0	0	0	0	0
ЭМТ	1	3,159.7			1	3,159.7						
ЕБС	1	1,471.0			1	1,471.0						
УТБ-ын дүн	2	4,630.7	0	0	2	4,630.7	0	0	0	0	0	0
ТТЗ												
ТТЗ-ийн дүн	0	-	0	0	0	-	0	0	0	0	0	0
Дүн	6	96,872.3	3	11,650.5	3	85,221.8	0	0	0	0	0	0

